



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### Аудитын код: АРА-2026/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Архангай аймаг 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn
--------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025. 02. 25 № 93

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН НАСАН  
ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНЧИМЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “ерөнхий боловсрол”, “насан туршийн болон албан бус боловсрол” хөтөлбөрүүдийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 432,008.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 365,648.8 мянган төгрөг зарцуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>78,532,733.30</b>	<b>94,091,704.14</b>
31	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>64,901,757.30</b>	<b>79,470,728.14</b>
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>64,901,757.30</b>	<b>79,470,728.14</b>
3121	<b>Төгрөг</b>	<b>64,901,757.30</b>	<b>79,470,728.14</b>
31211	Төрийн сангийн харилцах	64,901,757.30	79,470,728.14
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>13,630,976.00</b>	<b>14,620,976.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>10,932,000.00</b>	<b>11,922,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	10,932,000.00	11,922,000.00
354	<b>Хангамжийн материал</b>	<b>2,698,976.00</b>	<b>2,698,976.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,372,980.00	1,372,980.00
35420	Аж ахуйн материал	1,325,996.00	1,325,996.00
346	<b>Урьдчилж төлсөн зардал, тооцоо</b>	-	-
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,204,755,428.25</b>	<b>2,326,267,420.62</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,204,755,428.25</b>	<b>2,326,267,420.62</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,193,130,428.29</b>	<b>2,317,259,107.54</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,977,990,000.00	1,977,990,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,933,000.00)	(82,416,250.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	217,107,470.00	430,213,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,278,136.15)	(109,309,275.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,713,451.00	127,953,451.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,696,056.56)	(27,398,887.79)
39217	Ном	226,700.00	226,700.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,624,999.96</b>	<b>9,008,313.08</b>
39301	Програм хангамж	8,580,000.00	7,700,000.00
39302	Хасагдуулга	(1,455,000.04)	(2,941,666.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,500,000.00	4,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл - Бусад биет бус хөрөнгө	-	(250,020.00)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,283,288,161.55</b>	<b>2,420,359,124.76</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
413	<b>Өглөг</b>	-	-
4136	<b>Бусад өглөг</b>	-	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,283,288,161.55</b>	<b>2,420,359,124.76</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,283,288,161.55</b>	<b>2,420,359,124.76</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,283,288,161.55</b>	<b>2,420,359,124.76</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,086,706,408.17	2,283,288,161.55
51220	Тайлант үеийн үр дүн	196,581,753.38	137,070,963.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,283,288,161.55</b>	<b>2,420,359,124.76</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>708,186,295.44</b>	<b>624,539,400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>252,784,995.44</b>	<b>229,000,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>252,784,995.44</b>	<b>229,000,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	241,852,995.44	229,000,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	10,932,000.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>455,401,300.00</b>	<b>395,539,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>321,360,900.00</b>	<b>302,752,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	321,360,900.00	302,752,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,949,000.00</b>	<b>22,500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон	12,949,000.00	15,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>121,091,400.00</b>	<b>70,286,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,091,400.00	70,286,600.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>498,117,630.87</b>	<b>479,338,631.21</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>498,117,630.87</b>	<b>479,338,631.21</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>450,019,534.96</b>	<b>464,016,964.15</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>241,550,783.55</b>	<b>258,270,854.24</b>
210101	Цалин	135,302,927.05	161,485,909.61
210102	Нэмэгдэл цалин	46,638,853.54	54,035,194.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,316,000.00	18,380,000.00
210104	Урамшуулал	22,301,162.00	24,369,750.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,991,840.96	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,741,637.03</b>	<b>32,162,674.92</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,415,860.90	21,757,981.67
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,152,562.28	2,672,431.05
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,168,829.47	1,284,630.15
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	915,357.11	1,284,630.15
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,089,027.27	5,163,001.90
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53,995,581.09</b>	<b>54,964,932.94</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	1,471,695.00	2,579,462.00
210302	Түлш, халаалтын зардал	50,508,057.00	50,506,563.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,015,829.09	1,878,907.94
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,666,450.00</b>	<b>1,442,500.00</b>
210401	Бичиг хэргийн материал	648,800.00	1,421,100.00
210402	Тээвэр, шатахууны зардал	1,680,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,337,650.00	21,400.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>1,593,500.00</b>	<b>202,500.00</b>
210502	Хоол, хүнс	1,593,500.00	202,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,034,000.00</b>	-
210604	Урсгал засвар	9,034,000.00	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>5,969,000.00</b>	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,969,000.00	-

Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>105,468,583.29</b>	<b>116,973,502.05</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,856,040.00	4,576,700.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	6,629,158.00	13,038,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,983,385.29	99,358,202.05
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,098,095.91</b>	<b>15,321,667.06</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>48,098,095.91</b>	<b>15,321,667.06</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,098,095.91	15,321,667.06
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>210,068,664.57</b>	<b>145,200,768.79</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	13,486,911.19	8,129,805.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,486,911.19	8,129,805.58
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145- 225)</b>	(13,486,911.19)	(8,129,805.58)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>196,581,753.38</b>	<b>137,070,963.21</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>455,401,300.00</b>	<b>395,539,400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>455,401,300.00</b>	<b>395,539,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>334,309,900.00</b>	<b>302,752,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	321,360,900.00	302,752,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилт</b>		<b>22,500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		7,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,949,000.00	15,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>121,091,400.00</b>	<b>70,286,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,091,400.00	70,286,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>412,131,968.58</b>	<b>380,970,429.16</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,131,968.58</b>	<b>380,970,429.16</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>364,033,872.67</b>	<b>365,648,762.10</b>
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>241,550,783.55</b>	<b>258,270,854.24</b>
210101	Үндсэн цалин	135,302,927.05	161,485,909.61
210102	Нэмэгдэл	46,638,853.54	54,035,194.63
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	23,316,000.00	18,380,000.00
210104	Урамшуулал	22,301,162.00	24,369,750.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,991,840.96	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,741,637.03</b>	<b>32,162,674.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,415,860.90	21,757,981.67
210202	Тэтгэмжийн даатгал	2,152,562.28	2,672,431.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,168,829.47	1,284,630.15
210204	Ажилгүйдлийн даатгал	915,357.11	1,284,630.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,089,027.27	5,163,001.90
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>64,993,304.09</b>	<b>54,964,932.94</b>

**Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	1,471,695.00	2,579,462.00
210302	Түлш, халаалт	61,505,780.00	50,506,563.00
210303	Цэвэр, бохир ус	2,015,829.09	1,878,907.94
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	-	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,000,000.00</b>	-
210604	Урсгал засвар	8,000,000.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,969,000.00</b>	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,969,000.00	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,779,148.00</b>	<b>20,250,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,145,000.00	5,505,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,634,148.00	14,745,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,098,095.91</b>	<b>15,321,667.06</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>48,098,095.91</b>	<b>15,321,667.06</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	48,098,095.91	15,321,667.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	43,269,331.42	14,568,970.84
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,500,000.00	-
	Дотоод эх үүсвэрээр	1,500,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,500,000.00)	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>41,769,331.42</b>	<b>14,568,970.84</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>23,132,425.88</b>	<b>64,901,757.30</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>64,901,757.30</b>	<b>79,470,728.14</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,086,706,408.17	2,086,706,408.17
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,086,706,408.17	2,086,706,408.17
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	196,581,753.38	196,581,753.38
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,283,288,161.55	2,283,288,161.55
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,283,288,161.55	2,283,288,161.55

Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
4-05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
4-06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
4-07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	137,070,963.21	137,070,963.21
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	2,420,359,124.76	2,420,359,124.76

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>432,008,600.00</b>	<b>365,648,762.10</b>	<b>66,359,837.90</b>	<b>84.64</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>432,008,600.00</b>	<b>365,648,762.10</b>	<b>66,359,837.90</b>	<b>84.64</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>432,008,600.00</b>	<b>365,648,762.10</b>	<b>66,359,837.90</b>	<b>84.64</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>313,264,100.00</b>	<b>258,270,854.24</b>	<b>54,993,245.76</b>	<b>82.45</b>
Үндсэн цалин	210101	219,184,300.00	161,485,909.61	57,698,390.39	73.68
Нэмэгдэл	210102	86,486,800.00	54,035,194.63	32,451,605.37	62.48
Унаа хоолны Хөнгөлөлт	210103	-	18,380,000.00	(18,380,000.00)	-
Урамшуулал	210104	7,593,000.00	24,369,750.00	(16,776,750.00)	320.95
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>39,157,900.00</b>	<b>32,162,674.92</b>	<b>6,995,225.08</b>	<b>82.14</b>
Тэтгэврийн даатгал	210201	26,627,400.00	21,757,981.67	4,869,418.33	81.71
Тэтгэмжийн даатгал	210202	3,132,600.00	2,672,431.05	460,168.95	85.31
ҮОМШӨ-ний даатгал	210203	1,566,300.00	1,284,630.15	281,669.85	82.02
Ажилгүйдлийн даатгал	210204	1,566,300.00	1,284,630.15	281,669.85	82.02
Эрүүл мэндийн даатгал	210205	6,265,300.00	5,163,001.90	1,102,298.10	82.41
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>70,286,600.00</b>	<b>54,964,932.94</b>	<b>15,321,667.06</b>	<b>78.20</b>
Гэрэл, цахилгаан	210301	9,990,000.00	2,579,462.00	7,410,538.00	25.82
Түлш, халаалт	210302	56,821,600.00	50,506,563.00	6,315,037.00	88.89
Цэвэр, бохир ус	210303	3,475,000.00	1,878,907.94	1,596,092.06	54.07
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нормативт зардал</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>9,300,000.00</b>	<b>20,250,300.00</b>	<b>(10,950,300.00)</b>	<b>217.75</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	6,300,000.00	5,505,000.00	795,000.00	87.38
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	3,000,000.00	14,745,300.00	(11,745,300.00)	491.51
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Дотоод эх үүсвэрээр					
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>432,008,600.00</b>	<b>380,217,732.94</b>	<b>51,790,867.06</b>	<b>88.01</b>

<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>361,722,000.00</b>	<b>302,752,800.00</b>	<b>58,969,200.00</b>	<b>83.70</b>
Улсын төсвөөс санхүүжих	131001	302,752,800.00	302,752,800.00	-	100.00
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	58,969,200.00	-	58,969,200.00	-
<b>Нэмэлт санхүүжилт</b>	1311	-	<b>22,500,000.00</b>	<b>(22,500,000.00)</b>	-
ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	131103	-	7,500,000.00	(7,500,000.00)	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131104	-	15,000,000.00	(15,000,000.00)	-
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>70,286,600.00</b>	<b>54,964,932.94</b>	<b>15,321,667.06</b>	<b>78.20</b>
Орон нутгийн төсвөөс	132001	70,286,600.00	54,964,932.94	15,321,667.06	78.20
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		<b>64,901,757.30</b>	<b>64,901,757.30</b>	-	<b>100.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		<b>64,901,757.30</b>	<b>79,470,728.14</b>	<b>(14,568,970.84)</b>	<b>122.45</b>
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ БАЙГУУЛЛАГЫН ТОО					
АЖИЛЛАГСАДЫН ТОО		1.00	1.00		100.00
Удирдах ажилтан		8.00	8.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан		5.00	5.00	-	100.00
		3.00	3.00	-	100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 108.2 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрч, татварын тайланд залруулга хийлгэлээ.

- Нэр бүхий 1 ажилтны татварыг суутган төлсөн боловч 1,082.1 мянган төгрөгийн татвар ногдуулах орлогыг Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан (ТТ11)-т тайлагнаагүйгээс 108.2 мянган төгрөгийн татвар дутуу тайлагнажээ.

Аудитаар залруулаагүй 3,635.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 3,635.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,635.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 4,254.6 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Албан шаардлага

3.1.1. "210103 унаа хоолны хөнгөлөлт зүйлээр зардал төсөвлөөгүй, 'Боловсролын сайдын 2025.02.11-ний 1/554 дугаар бүхий чиглэл зөрчин хоолны хөнгөлөлтийг 2,076.0 мянган төгрөгөөр тус тус илүү олгожээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д "Харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх", Боловсролын сайдын 2025.02.11-ний 1/554 дугаар бүхий чиглэлд "орон нутагт хоногийн 5,000 төгрөг гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. "Балансын урамшуулал олгох тухай" тус газрын захирлын 2025.04.18-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татвар дутуу тайлагнасан	2	216.4	1.0	108.2			1.0	108.2		
Нийт дүн	2	216.4	1.0	108.2	-	-	1.0	108.2	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо

Архангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоолны хөнгөлөлт илүү тооцож олгосон	1	2,076.0			1	2,076.0				
Балансын урамшуулал олгосон	1	1,559.0			1	1,559.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,635.0</b>	-	-	<b>2</b>	<b>3,635.0</b>	-	-	-	-